



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар В/103

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх нь” аяны хүрээнд 1 дүгээр багийн иргэн Мөнхсайханы Бат-Эрдэнэ (6 настай), 3 дугаар багийн иргэн Дашнямын Ундармаа (5 настай) нарыг Өгөөмөр сувилалд 7 хоног сувилах сувилалын зардалд нийт 830,000 (найман зуун гучин мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 830,000 (найман зуун гучин мянган) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

